



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДЭРГЭДЭХ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,
Утас/факс: 261406
E-mail: info@frs.mn, http://www.frs.mn

2026.03.31 № 17
танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН, УИХ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Р.СЭДДОРЖ ТАНАА

УИХ-ын 2006 оны 56 дугаар тогтоолоор
батлагдсан Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх
хяналтын зөвлөлийн ажиллах журмын 7 дугаар
зүйлийн 7.2-т заасны дагуу зөвлөлийн 2025 оны үйл
ажиллагааны тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: 2/4 хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА



М.БУЯНДЭЛГЭР



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДЭРГЭДЭХ
ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ**

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН 2025 ОН**

АГУУЛГА

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	I
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	II
НЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ТУХАЙ.....	1
ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛУУД.....	3
ГУРАВ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ШИЙДВЭРҮҮД.....	11
ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ	17
ТАВ. ДҮРЭМ, ЖУРМЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ.....	21

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хяналтын зөвлөлын хуралдаан.....	8
Зураг 2. ББСБ-уудын тоо	12
Зураг 3. ББСБ-уудын хөрөнгө, хөрөнгийн өсөлт	12
Зураг 4. ББСБ-уудын хөрөнгө, хөрөнгийн өсөлт	12
Зураг 5. Зээлийн ангилал.....	13
Зураг 6.Зээлийн эрсдэлийн сангийн харьцаа.....	13
Зураг 7. ББСБ-уудын хөрөнгийн өгөөжийн харьцаа	14
Зураг 8. “Санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сургалт	17
Зураг 9. “Mongolia’s Capital Market Connectivity 2025” арга хэмжээ	18
Зураг 10. “Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг ТХХТ-ийн хүрээнд холбох боломж” зөвлөлдөх уулзалт	19
Хүснэгт 1. Өргөдөл, гомдол.....	3
Хүснэгт 2. Хуралдаан	5
Хүснэгт 3. Тогтоолууд салбараар	11

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НҮТББ	Нийгмийн үйлчилгээний төрийн бус байгууллага
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
МУИС	Монгол Улсын Их Сургууль
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
СЭЗИС	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
ОТС	Over-the-Counter

01

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН
ТУХАЙ

НЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ТУХАЙ

Хяналтын зөвлөл нь "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, УИХ-ын 2006 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан "Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/-ны дэргэдэх Хяналтын зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/-ийн ажиллах журам"-ын 1.2 дахь хэсэгт заасанчлан Хорооноос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг урьдчилан хянах, Хорооны үйл ажиллагаанд хяналт тавих, Хорооны үйл ажиллагааны талаар хөндлөнгийн аудитын гаргасан санал, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй орон тооны бус бүтэц юм. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа хуралдахаар журамласан байдаг.

Улсын Их Хурлын 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 72 дугаар тогтоолоор томилогдсон гишүүд нь өөр ажилд томилогдсоны улмаас ирц бүрэлдэхгүй байдалд хүрч Хорооны үйл ажиллагаатай холбоотой иргэд, зохицуулалттай этгээдүүдээс ирүүлсэн гомдлыг хэлэлцэн шийдвэрлэх боломжгүй байдалд хүрсэн тул УИХ-ын 2025 оны 01 сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр томилсон.


Зөвлөл нь "Хяналтын зөвлөлийн ажиллах журам"-д заасны дагуу хуралдааны дэгийг шинээр батлан долоо хоног бүрийн **Пүрэв гараг бүрд** хуралдаан болон уулзалт зохион байгуулан ажиллаж, Хорооны үйл ажиллагаа, бодлого, шийдвэртэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд дурдсан асуудал, хариуцагчийн тайлбар бусад холбогдох нотлох баримт, материалыг хянаж, гомдол гаргагч болон санхүүгийн зохицуулалттай салбарын үйлчилгээ эрхлэгч цаашид эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр санал, зөвлөмжийг гарган Хороонд хүргүүлэн ажиллаж байна.

Үүний зэрэгцээ хөрөнгийн зах зээл, банкнаас бусад санхүүгийн байгууллага, даатгал, санхүүгийн мэдээллийг ил тод байлгах, иргэдэд мэдээллийг хүртээмжтэй хүргэх, Хорооны үйл ажиллагаа хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд явж байгаа эсэхэд хяналт тавих, бүс, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, инновацад суурилсан гарааны бизнесийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, санхүүгийн зэх зээлийн шинэ талбар, инновац, шинэ технологийн шийдэлд тулгуурлан Хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор санхүүгийн зохицуулалттай салбарын олон улсын хөгжил, дэвшилтэд технологийн шийдлийг судалж, салбарын үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээдэд нээлттэй, түргэн шуурхай хүргэх талаар анхааран ажиллаж байна.

02

ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА,
ХЭЛЭЛЦСЭН
АСУУДЛУУД

ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛУУД



Өргөдөл, гомдол

Тайлант хугацаанд иргэд, зохицуулалттай этгээдээс нийт **12 өргөдөл, гомдол** ирүүлснийг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-т заасны хүрээнд Хорооны тогтоол шийдвэртэй холбоотой **9**, Хорооны үйл ажиллагаа, эрх бүхий албан тушаалтны (Улсын байцаагчийн албан шаардлага) шийдвэртэй холбоотой **2** гомдлыг хянаж Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу шийдвэрлэлээ. Үүнд:

Хүснэгт 1. Өргөдөл, гомдол

№	Хаанаас ирүүлсэн	Өргөдлийн утга	Огноо, бичгийн дугаар	Өгсөн хариу
1	"Улаанбаатар үнэт цаасны бирж" ХК	Гомдол гаргах тухай /Шийтгэлийн хуудасны талаар/	2025.01.13 №02/25	2025.02.11-ний өдрийн №04 дугаартай албан бичгээр Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шалгах тухай хуулийн дагуу харьяалах хууль хяналтын байгууллагад хандах талаар хариу хүргүүлсэн.
2	"Смарт брокерс" ХХК	Гомдол гаргах тухай /Тогтоол хүчингүй болгох талаар/	2025.02.26 №60/25	2025.03.21-ний өдрийн №09 дугаартай албан бичгээр хариу "Смарт брокерс" ХХК-д тогтоол хуулийн дагуу гарсаныг мэдэгдсэн. Мөн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 221/МА2025/0234 дугаартай магадлалаар "Смарт брокерс" ХХК-ийн оноосон нэрийг бүртгэлийг хасуулах нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

3	"Монголын даатгалын холбоо" НҮТББ	Гомдол гаргах тухай /Тогтоол хүчингүй болгох талаар/	2025.02.27 №25/11	2025.03.25-ний өдрийн №10 дугаартай албан бичгээр тодруулга авах шаардлагатай тул хуульд заасны дагуу 1 сар сунгасан тухай мэдэгдсэн. 2025.04.22-ны өдрийн Зөвлөлийн хуралдаанаар Хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулж, Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүрийг судалгааны үндсэн дээр дахин боловсруулж, батлахыг даалгаж шийдвэрлэсэн тухай албан бичгийг хүргүүлсэн.
4.	Иргэн Б.Ганбаяр	Дүрэм журамд оруулах санал	2025.04.17	2025.04.30-ны өдөр О.Оч гишүүн хүлээн авч биечлэн уулзаж, судалгаатай, тодорхой кейс үүссэн нөхцөлтэйгээр саналыг гаргахыг зөвлөв.
5.	Иргэн Ч.Мөнгөнжигүүр	Даатгалын нөхөн төлбөр гаргуулах тухай	2025.06.02	2025.06.20-ны өдрийн 27 дугаартай албан бичгээр СЗХ-д Өргөдлийг дахин судалж, үндэслэл бүхий тайлбар өгүүлэхээр албан бичиг хүргэгдсэн. СЗХ-оос гомдлыг дахин хэлэлцээд нөхөн төлбөрийг олгуулах талаар албан бичгийг иргэн Ч.Мөнгөнжигүүрт хүргүүлсэн.
6.	Иргэн Г.Хосбаяр	Гомдол гаргах нь	2025.08.07	С.Халиунаа гишүүн биечлэн уулзаж, зөвлөгөө өгч шийдвэрлэсэн.
7.	"Говь" ХК	СЗХ-ны хяналт шалгалтын тайланг хүчингүй болгуулах	2025.09.30 №01/673	2025.10.30-ны өдрийн 33 дугаартай албан бичгээр СЗХ-ны гаргасан шийдвэр нь хууль тогтоомжийн хүрээнд гарсан шийдвэр тул хүлээн авах боломжгүй гэсэн хариуг хүргүүлсэн.
8.	"Атар өргөө" ХК	СЗХ-ны хяналт шалгалтын тайланг	2025.10.31 №151	2025.12.11-ний өдрийн хуралдаанаар гомдлыг хэлэлцээд Санхүүгийн зохицуулах хорооноос хийгдсэн хяналт, шалгалтын

	хүчингүй болгуулах		хүрээнд гарсан дүгнэлт, өгсөн үүрэг даалгавар бүхий мэдэгдэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байна гэж шийдвэрлэв.
9.	“Атар өргөө” ХК	СЗХ-ны хяналт шалгалтын тайланг хүчингүй болгуулах хугацаанд актын биелэлтийг түдгэлзүүлэх	2025.10.3 1 №152
10	Иргэн Д.Мөнхтуяа	Атар өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигч хууль зөрчиж буй талаар	2025.11.2 0 Үүссэн нөхцөл нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөж буй эсэх, нэмэлт зохицуулалт шаардлагатай эсэх дэлгэрэнгүй судалж, Хороонд чиглэл хүргүүлэхээр ажиллаж байна.
11	“Говь” ХК	СЗХ-ны хяналт шалгалтын тайланг хүчингүй болгуулах	2025.11.2 0 Хянагдаж байна.

Хуралдаан

Зөвлөл нь тайлант хугацаанд **21 удаагийн хуралдаан** зохион байгуулсан бөгөөд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэхээс гадна Хорооны үйл ажиллагаа, зохицуулалттай салбарууд болон мэрэгжлийн холбоодтой зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, үйл ажиллагааны онцлог, цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл авч, тулгамдаж буй асуудлуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар зөвлөлдөн ажилласан ба иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч биечлэн уулзаж, гаргасан гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаа. Үүнд:

Хүснэгт 2. Хуралдаан

№	Уулзалтын нэр	Огноо	Тайлбар
1	Санхүүгийн зохицуулах хорооны газар	2025.01.29	Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа удирлдагын газар, Даатгалын газар, Үнэт

нэгжүүдийн танилцуулга уулзалт	сонсох	цаасны газруудтай уулзалт зохион байгуулав	
2	Санхүүгийн зохицуулах хорооны газар нэгжүүдийн танилцуулга	2025.02.04	Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газар, Хадгаламж, зээлийн хоршооны газар, Хяналт шалгалт, зохицуулалтын газар, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар, Үл хөд;өх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газруудтай уулзалт зохион байгуулав.
3	"Монголын хөрөнгийн бирж" ХК,"Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-тай тус тус уулзалт хийв	2025.02.07	"Монголын хөрөнгийн бирж" ХК, "Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-тай тус тус танилцах уулзалт хийв.
4	Монголын Даатгалын нэгдсэн холбоо НҮТББ-тай уулзалт зохион байгуулав	2025.02.27	Тус уулзалтаар тулгамждак буй асуудлуудыг хэлэлцэв.
5	Санхүүгийн зохицуулах хорооны газар нэгжүүдийн танилцуулга сонсох уулзалт	2025.03.20	Гадаад харилцааны газар, Компанийн засаглал, комплайнсын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэлтсийг хүлээн авч уулзан, танилцуулгыг сонсов.
6	Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой уулзалт зохион байгуулав	2025.04.03	Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны ерөнхийлөгч З.Алтанзул, удирдах зөвлөлийн гишүүн н.Алтансүх, н.Жавхлантөгс нартай уулзалтыг зохион байгуулав.
7	Хорооны 2025 онд гарсан тогтоол шийдвэрүүдтэй танилцах	2025.04.03	Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны улиралд гаргасан хурлын тогтоол шийдвэртэй танилцав.
8	Хорооны 2025 оны 01 дугаартай тогтоолд өөрчлөлт оруулах асуудлаар 3 удаа хэлэлцсэн	2025.04.22	Зөвлөлийн хуралдаанаар Хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулж, Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүрийг судалгааны

			үндсэн дээр дахин боловсруулж, батлахыг даалгаж шийдвэрлэсэн.
9	Хувьцаат компанийн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс “Хуулийн хэрэгжилтийн хангуулах тухай” 2025 оны 03 дугаар тогтоолыг гаргав.	2025.06.13	“Атар өргөө” ХК-ийн жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болох Д.Мөнхтуяа, Ц.Аюуш нарыг хүлээн авч уулзаж нөхцөл байдлыг сонссон бөгөөд Хяналтын зөвлөл хуралдаж Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хэрэгжилт, компанийн харилцагч, хөрөнгө оруулагч, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор нээлттэй зах зээл дээрээс худалдан авсан хувьцаа нь саналын эрхтэй эсэх талаар холбогдох шийдвэр гаргаж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хороонд үүрэг болгож шийдвэрлэсэн.
10	Санхүүгийн зохицуулах хороонд Хяналтын зөвлөлөөс гарсан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах, биелэлтийг улирал тутамд тайлагнах талаар чиглэл хүргүүлсэн.	2025.08.01	Хяналтын зөвлөл нь Хорооны үйл ажиллааатай холбогдуулан гаргасан 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “Тогтоолын зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай” 02 дугаар тогтоол, 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” 03 дугаар тогтоолуудын хэрэгжилт, түүний түүний явцын талаарх мэдээллийг ирүүлэ, цаашид сар бүрийн 7 хоногийн баасан гарагаар тасалбар болгон хорооны гаргасан тогтоолуудыг ирүүлж байхыг үүрэг болгов.
11	Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, Өмгөөлөгч О.Батхүүгийн гаргасан “Даатгалын багц дүрэм”-ийг хүчингүй болгуулах асуудлыг хэлэлцсэн.	2025.08.15	Уг асуудлын хүрээнд иргэд ипотекийн зээлийн үйлчилгээг авахад сайн дурын даатгалд хамрагдах эсэх асуудал нь өөрсдийнх нь сонголтоор шийдвэрлэгдэх болсон талаар албан бичгээр хариу хүргүүлсэн.
12	Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны	2025.09.30	Санхүүгийн зохицуулах хорооны Газар нэгжүүдийн хагас жилийн тайланг сонсож,

эхний хагас жилийн тайлантай танилцаж зарим асуудлаар үүрэг чиглэл өгөв.	ББСБ-ын 2022-2025 оны статистик тоон мэдээг гаргуулах, цаашид нэгж бүр улирлын тайланг танилцуулж байх талаар тогтов.
13 “Говь” ХК нь хэлбэрээ өөрчилж “Говь” ХХК болгохоор гаргасан шийдвэрийн хүрээнд СЗХ-оос тус компанид хүргүүлсэн мэдэгдлийг 2025.10.30 хүлээн зөвшөөрөх боломжгүй талаар “Говь” ХК-иас Хяналтын зөвлөлд гаргасан гомдлыг хэлэлцэв.	Хяналтын зөвлөлд гаргасан танай гомдлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 31/3429 дугаартай албан бичиг, 2025 оны 3/3469 дугаартай албан бичгүүд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-т “Хороо дараах тохиолдолд өөрийгөө зохицуулах байгууллага, зохицуулалттай этгээд болон үнэт цаас гаргагчид даалгавар өгөх эрхтэй” гэж заасан бөгөөд 66 дугаар зүйлийн 66.1.1-т “харилцагч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах шаардлага бий болсон”, 66.1.5-т “хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахад шаардлагатай гэж Хорооноос үзсэн бусад тохиолдол”, мөн “Говь” ХК-ийн жижиг хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдаас Санхүүгийн зохицуулах хороонд гаргасан гомдлыг тус тус үндэслэн хууль, тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцүүлэн гаргасан үүрэг даалгавар байна гэж дүгнэв.

Албан бичиг

Тайлант хугацаанд Улсын Их Хурлын гишүүн, Монгол банк, Арилжааны банк, Санхүүгийн зохицуулах хорооноос нийт **7 албан бичиг** ирсэн бөгөөд Хяналтын хорооноос мэдээлэл хүссэн албан бичгийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хугацаанд нь хариуг хүргүүлэн ажиллалаа.

Зураг 1. Хяналтын зөвлөлын хуралдаан



03

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ
ШИЙДВЭРҮҮД



ГУРАВ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ШИЙДВЭРҮҮД

2025 оны байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны 18 удаагийн хуралдаанаас нийт **456 тогтоол** албажсан байна. Тогтоолуудыг зохицуулалттай салбараар ангилан харвал:

**Хүснэгт 3. Тогтоолууд салбараар**

№	Төрөл	Нийт тогтоолын тоо	Шийдвэрийн агуулгаар	
			Бодлого зохицуулалт	Бүртгэл, зөвшөөрөл
1	Үнэт цаасны газар	113	21	92
2	Даатгалын газар	33	7	26
3	Банк бус санхүүгийн байгууллагын газар	42	8	34
4	Хадгаламж, зээлийн хоршооны газар	7	1	6
5	Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар	157	-	157
6	Хяналт шалгалт, зохицуулалтын газар	93	-	93
7	Захиргаа удирдлагын газар	2	2	-
8	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэлтэс	3	2	1
9	Мөнгөн зээлийн зохицуулалтын алба	5	-	5
10	Сэндбоксын алба	1	1	-
Нийт		456	42	414

Үүнээс онцлох бодлогын шийдвэрүүд нь Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 68 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг, хоёрдугаар хавсралтаар “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ыг тус тус баталсан байна.

Банк бус санхүүгийн байгууллага


Банк бус санхүүгийн байгууллагын (ББСБ) тоо өмнөх оны мөн үеэс **8.3** хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 2. ББСБ-уудын тоо



ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс **49.2** хувиар өсөж **7.6 их наяд** төгрөгт хүрсэн байна. Тайлант улиралд нийт эх үүсвэрийн **38.7** хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байгаа бол нийт хөрөнгийн **89.5** хувийг нийт зээлийн өсөлт эзэлж байна.

Зураг 3. ББСБ-уудын хөрөнгө, хөрөнгийн өсөлт



Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс **54.6** хувиар өсөж **6.3 их наяд** төгрөгт хүрсэн байна.

Зураг 4. ББСБ-уудын хөрөнгө, хөрөнгийн өсөлт



Нийт зээлийн үлдэгдлийн **88.8** хувийг хэвийн, **4.6** хувийг хугацаа хэтэрсэн, **6.6** хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 77 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д, 78 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Журмын өөрчлөлтийн хүрээнд ББСБ-аас олгох хэрэглээний зээлд өр, орлогын харьцаа 60 хувиас хэтрэхгүй ба суудлын автомашин барьцаалсан зээл, зээл үнэлгээний харьцаа 60 хувиас бага байхаар тус тус өөрчлөлт оруулсан байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 88.8 хувийг хэвийн, 4.6 хувийг хугацаа хэтэрсэн, 6.6 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна.

Зураг 5. Зээлийн ангилал



Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс **0.3** пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

ББСБ-ын салбарын хувьд эрсдэлийн сангийн харьцаа **112.0** хувь гарч байгуулбал зохих эрсдэлийн санг бүрдүүлж ажилласан байна.


Зураг 6. Зээлийн эрсдэлийн сангийн харьцаа



ББСБ-уудын нийт өр төлбөрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс **71.2** хувь өсөж **3.7 их наяд** төгрөгт хүрлээ. Мөн өөрийн хөрөнгө 33.0 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө 8.6 хувиар тус тус өссөн байна.

ББСБ-уудын ашигт ажиллагааг илэрхийлэгч чухал үзүүлэлт болох нийт хөрөнгийн өгөөж **3.7** хувь, өөрийн хөрөнгийн өгөөж **6.9** хувьтай байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хөрөнгийн өгөөж **0.4** пунктээр, өөрийн хөрөнгийн өгөөж **1.3** пунктээр тус тус өссөн байна.

Зураг 7. ББСБ-уудын хөрөнгийн өгөөжийн харьцаа



Нийт **573** ББСБ-ийн **1,464.29** сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс **83.3** хувь буюу **462** ББСБ-аас **1,220.06** сая төгрөг Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Тогтоолд өөрчлөлт оруулсантай холбогдуулан хэрэгжиж байсан тогтоол болон шинэчлэн баталсан тогтоолд дүн шинжилгээ хийгээд банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны талаар Санхүүгийн зохицуулах хорооноос тавьж буй бодлогыг боловсронгуй болгох, 2025 оны 68, 71 дүгээр тогтоолоор баталсан журмууд нь санхүүгийн зохицуулалттай харилцаанд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, хэрэглээний болон бизнесийн зээлийн хувь хэмжээг багасгах, хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаадаас татан төвлөрүүлж буй хөрөнгөөс татах татварын хувь хэмжээг олон улсын жишигт нийцүүлэх, эх үүсвэр нь тодорхойгүй, хувиараа зээл олгож буй зээлийг тодорхой болгох, мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн гаралтыг багасгах нөхцөл, боломжийг судлан бодлогоор дэмжүүлэх ажлыг хороотой хамтран хэрэгжүүлнэ.

Учир нь банк бус санхүүгийн байгууллага нь хэрэглээний болон бизнесийн зээлийг банкны үйлчилгээ хүрч чадахгүй хэсэгт хүрч ажилладгаараа онцлог бөгөөд зээлийн үйлчилгээ үзүүлэгч нь зээл хүсэгчдэд хүрч чадахгүй байдал үүсэж, хар зах зээл буюу өдрийн өндөр хүүгээр хувь этгээдээс зээл авах, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхлэх хууль бус үйл ажиллагааг нэмэгдүүлж болзошгүй байна.

Сүүлийн 6 сарын хугацаанд өр, орлогын харьцаа **80/20** байсныг **60/40** болгон зохицуулалт хийсэн. Энэ нь санхүүгийн эрэлт, хэрэгцээнд нийцэж байгаа эсэх, иргэдийн

өр, орлогын харьцаа, шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх, зохистой хэмжээнд барих, иргэдэд санхүүгийн дарамт учруулахгүй талаас бодлогын шийдвэрүүдийг гаргах тал дээр анхаарч, ногоон зээлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

Мөн ББСБ гадаадаас татан төвлөрүүлж буй хөрөнгийн эх үүсвэрээс аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хэмжээ 20 хувиар тогтоосон нь ББСБ-аас иргэн, хуулийн этгээдэд олгож буй хэрэглээний болон бизнесийн зээлийн хувь хэмжээг багасгах боломжгүй болгож буй нь зохицуулалттай үйлчилгээ эрхлэгчдэд нэн тулгамдаж буй асуудал бөгөөд Банк гадаадаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээтэй ижил хэмжээгээр буюу 5 хувьтай тэнцэх хэмжээгээр нэмэлт өөрчлөлт оруулах талаар ББСБ-ын төлөөллүүд санал гаргасныг судалж байна.

04

**ХАМТЫН
АЖИЛЛАГААГ
ӨРГӨЖҮҮЛЭХ**



ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ

Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр цахим мөрийтэй тоглоомд насаараа хуримтлуулсан мөнгөө алдсан, өрөнд орсон иргэдийн тоо өссөөр байгаа төдийгүй олон иргэн бусдаас мөнгө зээлж, найз нөхдөө уруу татах замаар хохирлыг нэмэгдүүлж, үүний улмаас манай улсаас **1.7 их наяд** төгрөг буюу **500 сая ам.доллар** гадаад улс руу шилжсэн талаар мэдээлэх болсон.

Үүнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13-т заасан иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах замаар эрсдэлийг бууруулах боломжтой гэж үзэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дах заалтын хүрээнд Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран төрийн албан хаагчдад санхүүгийн залилангаас сэргийлэх болон хөрөнгийн зах зээлийн сургалтыг санхүүгийн платформ дээр тулгуурлан явуулах үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна.

“Санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сургалт

Энэ ажлын эхлэл болгон Зөвлөлөөс санаачлан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Нийслэлийн цагдаагийн удирдах газартай хамтран хөрөнгийн зах зээл, санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлэх болон хүрээлэн буй орчны төлөвлөлтөөр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох зорилгоор тус сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан.

Сургалтад Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн дарга М.Буяндэлгэр, Хорооны орон тооны гишүүн бөгөөд дэд дарга Т.Цэрэнбадрал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга Л.Нямгэрэл, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга, цагдаагийн хурандаа Э.Товуудорж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгчид болон Монголын хөрөнгийн бирж, Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Нийслэлийн бодлогын судалгаа, шинжилгээний төвийн төлөөлөл, сургагч багш нар, мөн дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн дарга нарын нийт 40 гаруй албан тушаалтныг хамруулсан.

Зураг 8. “Санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сургалт





Үүний үр дүнд санхүүгийн онлайн залилангаас урьдчилан сэргийлэх мэдлэг олгох ажлыг салбар бүрт мэдээлэл болгон түгээх, онлайн бооцоот тэмцээн уралдаанд гарах мөнгөн хөрөнгийг хувьцаа болон хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах зэргээр албан хаагчдын санхүүгийн үйл ажиллагаанд дэмжлэг болох мэдлэгийг олгох, хөрөнгийн зах зээлд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тогтвортой санхүүгийн эх үүсвэртэй болох мэдлэгийг олгох талаар хамтран ажиллахаар тогтов.

Сургалтаар төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, иргэдийг санхүүгийн мэдлэг, мэдээллээр хангах, залилах гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таних мэдлэг олгох, хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгож, хууль эрх зүйн орчныг сайжруулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлж, мэдээлэл солилцооны үр нөлөөг нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хөрөнгийн зах зээл, санхүүгийн залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдол бүхий сургалтыг зохион байгуулсан.

"Mongolia's Capital Market Connectivity 2025" арга хэмжээ

Санхүүгийн зохицуулах хорооноос Монголын хөрөнгийн зах зээлийг олон улсын санхүүгийн төвүүдтэй холбох, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг нээх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор зохион байгуулж буй арга хэмжээ нь Улаанбаатар хотноо 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан.



Зураг 9. "Mongolia's Capital Market Connectivity 2025" арга хэмжээ

Энэхүү арга хэмжээнд дэлхийн хөрөнгийн зах зээлийн 30 гаруй хувийг удирддаг Ази тивийн 20 гаруй улсын 100 гаруй мэргэжилтэн, Азийн үнэт цаасны форумын гишүүн холбоод, нэр хүндтэй хөрөнгийн бирж, үнэт цаасны компаниудын төлөөлөл

оролцсон бөгөөд Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн чиг

хандлагын талаар танилцуулсны зэрэгцээ уул уурхайн олон улсын хөрөнгө оруулалт, хөрөнгө босгох стратеги, банкны үйл ажиллагаа ба санхүүжилтийн шинэ гарцууд, Ази, Европ болон бусад бүс нутгийн хөрөнгө оруулагчидтай хил дамнасан хамтын ажиллагааны талаар хуралд орсон олон улсын төлөөлөгчидтэй зөвшилцөж, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тогтов.

“Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг ТХХТ-ийн хүрээнд холбох боломж” зөвлөлдөх уулзалт

Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд холбох боломжийн талаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав. Нийслэлийн Засаг даргын 1 дүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн бодлогын судалгааны хүрээлэнгийн захирал Дагва болон МУИС, ШУТИС, СЭЗИС, МУБИС-ийн эрдэмтэн, докторуудтай нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагаанд туссан Хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт, түүнийг хэрхэн шийдвэрлэх, цаашид нийслэлийн хөрөнгө оруулалтын бодлогыг хөрөнгийн зах зээлтэй хэрхэн холбох, түүнээс иргэд хэрхэн үр өгөөж хүртэх, бонд болон үнэт цаасны зах зээлд хэрхэн оролцох боломжийг харилцан зөвлөлдөв.

Зураг 10. “Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг ТХХТ-ийн хүрээнд холбох боломж” зөвлөлдөх уулзалт



05

ДҮРЭМ, ЖУРМЫГ
БОЛОВСРОНГУЙ
БОЛГОХ



ТАВ. ДҮРЭМ, ЖУРМЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ**Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хуулийн хийдлийг арилгах чиглэлээр**

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуулийг хэрэгжүүлэх хуулийн хийдлийг арилгуулах ажлын хүрээнд

- Хувьцаа нь хяналтын багц болон түүнээс дээш хэмжээнд хүрсэн бол хяналтын багц эзэмшигч болсон өдрөөс хойш ажлын **60** өдрийн дотор бусад хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн зургаан сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал гаргах үүргийг хэрэгжүүлэх;
- Хувьцаат компанийн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг зөрчсөн, татвар хураамжаас зайлсхийсэн байж болзошгүй шүүхийн шийдвэрээр зээлийн гэрээний хүрээнд компанийн эзэмшиж байсан хувьцааг үүргийн гүйцэтгэлийг хангуулан иргэнд шилжүүлсэн үйлдлийг илрүүлэн

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам”-ын холбогдох хэсгийг хууль тогтоомжид нийцүүлэн, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах талаар зохицуулалтыг тусган өөрчлөлт оруулах талаар Хороонд тогтоолоор үүрэгжүүлэн ажилласан.

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 68 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг, хоёрдугаар хавсралтаар “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ыг тус тус баталсан ба 2025 оны 71 дүгээр тогтоолоор өр, орлогын харьцаа **80/20** байсныг **60/40** болгон зохицуулалт хийсэн.

Энэхүү шийдвэр нь санхүүгийн эрэлт, хэрэгцээ, иргэдийн өр, орлогын харьцаа, шаардлагад нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийх, зохистой хэмжээнд барих, иргэдэд санхүүгийн дарамт учруулахгүй талаас нь анхаарах шаардлагатай байна. Учир нь банк бус санхүүгийн байгууллага нь хэрэглээний болон бизнесийн зээлийг банкны үйлчилгээ хүрч чадахгүй хэсэгт хүрч ажилладгаараа онцлог бөгөөд зээлийн үйлчилгээ үзүүлэгч нь зээл хүсэгчдэд хүрч чадахгүй байдал үүсэж, хар зах зээл буюу өдрийн өндөр хүүгээр хувь этгээдээс зээл авах, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхлэх хууль бус үйл ажиллагааг нэмэгдүүлж болзошгүй байна.

Мөн ББСБ гадаадаас татан төвлөрүүлж буй хөрөнгийн эх үүсвэрээс аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хэмжээ **20** хувиар тогтоосон нь ББСБ-аас иргэн, хуулийн этгээдэд олгож буй хэрэглээний болон бизнесийн зээлийн хувь хэмжээг багасгах боломжгүй болгож буй талаар зохицуулалттай үйлчилгээ эрхлэгчдэд нэн тулгамдаж буй

асуудал бөгөөд Банкны татвартай ижил хэмжээгээр 5 хувьтай тэнцэх хэмжээгээр нэмэлт өөрчлөлт оруулах талаар ББСБ-ын төлөөллүүд санал ирүүлээд байна.

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны ерөнхийлөгч З.Алтанзул нарын төлөөлөгчдийг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хүлээн авч уулзсан. Уулзалтаар Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 68, 71 дүгээр тогтоолоор баталсан нэмэлт өөрчлөлтөөр учирч болзошгүй эрдслүүдийг хэрхэн шийдвэрлэх боломжийн талаар хэлэлцсэн. Үүнд:

- Төрийн зарим чиг үүргийг тухайлбал, Комплайнс, харилцагчийг хамгаалах, иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, сертификатжуулах сургалтуудын үйл ажиллагааг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх;
- Монгол банкны своп хэлцэлд шууд оролцох боломжийг судлан шийдвэрлүүлэх, гадаадын санхүүжилтийг дэмжүүлэх;
- Гадаадаас татсан зээлд хүүгийн орлогод ногдуулах татварын хувь хэмжээг бууруулах талаар төрийн байгууллагуудад саналыг тавьж, хуулийн өөрчлөлтийг эрх бүхий байгууллагад уламжлуулах;
- Гадаадаас татан төвлөрүүлсэн хөрөнгөөр бүрдүүлсэн гадаад валютын хадгаламжийг барьцаалан арилжааны банкнаас төгрөгийн зээл авах боломжийг судлан шийдвэрлүүлэх;
- Харилцагчийн хамгаалах олон улсын стандартыг /Cerise SPTF/ салбарт нэвтрүүлэх Хорооны зүгээс бодлогын дэмжлэг үзүүлэх талаар уламжлуулах зэрэг асуудлууд багтсан.

Тус асуудлуудыг олон улсад хэрхэн шийдвэрлэдэг, түүнийг Монголын санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломж, үр нөлөөллийн талаарх судалгааны ажлыг гүйцэтгэх шаардлагатай байгаа болно. Энэ талаар нарийвчилсан судалгааны ажил 2026 онд хийлгэх зардлыг Хорооны төсөвт тусгах саналыг хүргүүлээд байна.

Даатгалын салбарын үйл ажиллагааны чиглэлээр

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 1/114 дугаартай албан бичгээр хорооны 2024 оны 493 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангаас хассан. Үүний дагуу Хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолоор Хорооны “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр тооцох журам” тогтоосон 2024 оны 493 дугаар тогтоолыг хүчингүй болгон шийдвэрлэсэн.

Тус шийдвэртэй холбоотойгоор даатгалын олон улсын чиг хандлага, иргэдийн амьжиргааны түвшин, санхүүгийн чадамжид уялдуулан жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн шинэчлэн боловсруулах талаар Зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаартай тогтоолыг гарган Хороонд хүргүүлэн ажиллав. Дүрэм зөрчдөг, хариуцлагагүй жолооч буюу эрсдэл өндөртэй жолоочийн даатгалын төлөх хувь өндөр, хууль тогтоомж, дүрэм журмыг баримталдаг, осол гаргаж байгаагүй, эрсдэл бага жолоочийн төлөх төлбөрийг бага байх зарчмыг

баримталж даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр тогтоох талаар Хороонд чиглэл хүргүүлэн ажилласан.

Ипотекийн даатгалын үйл ажиллагааны чиглэлээр

Даатгалын багц дүрэмд оруулсан өөрчлөлтөөс шалтгаалан ипотекийн зээлтэй иргэдийг урт хугацааны даатгалын бүтээгдэхүүнд албадан хамруулах нөхцөл байдал үүсэх эрсдэлийг арилгах, ипотекийн зээлтэй холбоотой даатгалын төрлийг тодорхой, нэг мөр болгох зорилгоор Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох бодлого, зохицуулалтын чиглэл өгч хамтран ажиллаа. Учир нь тус дүрэмд зааснаар иргэдийг албадан даатгалд хамруулах нөхцөл байдал үүсэж болзошгүй байсан тул энэ талаар гомдол, санал ирүүлсэн иргэн, хуулийн этгээдтэй гишүүд биечлэн уулзан, холбогдох үндэслэл, тайлбарыг гаргуулан авсан болно.

Гомдол гаргагч болон хариуцагч байгууллагатай хамтран ажилласны дүнд ипотекийн зээлийн үйлчилгээ авах иргэд даатгалын үйлчилгээнд заавал хамрагдах бус, сайн дурын үндсэн дээр сонголтоо хийх эрх зүйн баталгааг хангаж, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 300 тоот тогтоолыг шинэчлэн батлууллаа. Уг төрийн зохицуулалт нь иргэдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн шударга, ил тод байдлыг хангах бодлогын шийдвэр болсон.

Хөрөнгийн зах зээлийн чиглэлээр

ОТС зах зээл, банк бус санхүүгийн байгууллагууд түүнчлэн олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн хувьцаат компаниудын үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгө оруулагчдын эрх, зах зээлийн ил тод байдал, шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөхүйц эрсдэл, зохицуулалтын хийдлийг арилгах зорилгоор ОТС зах зээлд арилжаалагдаж буй үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн ил тод байдал хангалтгүй, хөрөнгө оруулагчдад учрах эрсдэл бодитоор үнэлэгдэхгүй байгаа, ББСБ-уудын зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх, үнэт цаас гаргах, өрийн хэрэгсэл ашиглах үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлага, тайлагнал, хяналтыг сайжруулах, хувьцаат компаниуд болох Говь ХК, СУ зэрэг олон нийтэд нээлттэйгээр хөрөнгө татан төвлөрүүлсэн зарим хувьцаат компаниуд ХК хэлбэрээр хөрөнгө босгосны дараа ХХК болж хаалттай хэлбэрт шилжих оролдлого, чиг хандлага нэмэгдэж, энэ нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх, зах зээлийн итгэлцэлд сөргөөр нөлөөлөх бодит эрсдэл үүсгэж байна.

Үүнтэй холбогдуулан ОТС зах зээлийн эрсдэлийн үнэлгээ хийж, арилжаалагдаж буй үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн ил тод байдал, мэдээллийн хүртээмж, хөрөнгө оруулагчийг хамгаалах механизмыг сайжруулах санал, зохицуулалтын өөрчлөлтийн төслийг боловсруулах; ББСБ-уудын санхүүгийн эрсдэл, хөшүүрэг, хөрөнгө татан төвлөрүүлэлтийн бүтцийг тодорхой болгож, иж бүрэн дүн шинжилгээ хийх, шаардлагатай бол тайлагнал, хяналт, эрсдэлийн удирдлагын шалгуурыг чангатгах, Олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн ХК-ууд ХХК болж хэлбэрээ өөрчлөхтэй холбоотой эрх зүйн орчныг нарийвчлан судалж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах тусгай шаардлага, хязгаарлалт, шалгуурыг тодорхой болгох, хувьцаат компани хаалттай хэлбэрт шилжих тохиолдолд заавал мөрдөх ил тод, шударга үнэлгээ, худалдан авах санал, хяналтын

журмыг боловсронгуй болгох санал боловсруулах, эдгээр асуудлуудтай холбоотой дүрэм, журам, зааврыг нэг мөр, ойлгомжтой болгох, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах талаар Санхүүгийн зохицуулах хороонд чиглэл хүргүүлэн ажилласан.

Компанийн засаглалын чиглэлээр

Цаашид санхүүгийн зах зээлд тавигдах хяналтыг сайжруулах, хууль тогтоомжид нийцүүлэх, илэрч буй зөрчил, дата баазад үндэслэн анхаарах шаардлагатай салбарыг илрүүлэх, олон улсын туршлага, стандартуудыг нэвтрүүлэх, хяналтын арга замуудыг өргөжүүлэх, санхүүгийн зах зээлийн тайлан, стандарт, хяналтын явцын мэдээллийг олон нийтэд ил тод байлгах, хяналт, зохицуулалтын үүрэгтэй холбоотой судалгаа явуулах, хяналтын үр дүнг дүгнэх, хууль тогтоомжийн шинэчлэлт, комплайнсын нийцэлд дүн шинжилгээ хийх, зохицуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын хууль, эрх зүйн орчин, даатгалын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, виртуал хөрөнгийн зах зээлийн харилцааг боловсронгуй болгох, Хяналтын багийн гишүүдийн чадавхыг сайжруулах, иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх тал дээр Санхүүгийн зохицуулах хороотой үйл ажиллагааны уялдаа холбоог нэмэгдүүлэх тал дээр анхаарч, цаашид хяналтын үйл ажиллагааг сайжруулж, санхүү, хөрөнгийн зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар төлөвлөн ажиллаж байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДЭРГЭДЭХ “ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ”